

БОЛОВСРОЛЫН БАРИМТ БИЧГИЙГ ДАХИН ОЛГОХ ТУХАЙ

БСШУС-ын сайдын 2019 оны 159 дугаар тушаалаар батлагдсан “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ын 5 дахь заалтын дагуу гэрчилгээ, үнэмлэхийг үрэгдүүлсэн, гэмтээсэн, хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд дахин олгоно.

БОЛОВСРОЛЫН БАРИМТ БИЧГИЙГ ДАХИН АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

1. Иргэний хүсэлт (төгссөн сургууль, он, анги, баримт бичгийг дахин авах болсон шалтгаан, утасны дугаарыг бичнэ)
2. Сургуулийн лавлагаа
 - гэрчилгээ, үнэмлэх анх олгосон сургуулийн тодорхойлолт (төгссөн он, анги, АУБ-ийн нэр, олгосон боловсролын бичиг баримтын дугаарыг бичнэ, хэрэв боловсролын бичиг баримтын дугаар олдохгүй бол энэ тухай тэмдэглэнэ)
 - дүнгийн Б маягтын хуулбар
 - гэрчилгээ, үнэмлэхийн хуулбар
3. Иргэний үнэмлэх (эх хувь, хуулбарын хамт)
4. Боловсролын бичиг баримтын үнэ

ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ДАРААХ МАТЕРИАЛЫГ НЭМЖ БҮРДҮҮЛНЭ.

- Иргэний хувийн мэдээлэлд өөрчлөлт орж, боловсролын баримт бичиг дахин авах шаардлагатай болсон бол:
 - нотлох баримтын хуулбар (овог, нэр сольсон гэрчилгээ)
 - боловсролын баримт бичгийг эх хувиар нь авчирч хураалгана.
- 2006 оноос өмнө төгсөгчид дүнгийн Б маягт олдоогүй бол:
 - Төгсөх ангийн журналын жилийн эцсийн дүнгийн хуулбар
 - Сурагчийн хувийн хэрэг, хуулбарын хамт (хувийн хэргийн нүүр, хувийн хэрэг анх нээсэн болон сурлагын үнэлгээ дүн, сургууль төгссөн тухай тэмдэглэлийг хуулбардана)

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР

Холбоо барих утас: 99352648